



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 642

Улаанбаатар хот

“Ви пропертиз эстэйтс” ХХК-д хувьцаа
эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Ви пропертиз эстэйтс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2.Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Ви пропертиз эстэйтс” ХХК (Г.Гүнчин-Иш)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  ДБАЯРСАЙХАН

